



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/232

Булган сум

### “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4, 9.3.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XI хуралдааны XI/79 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны А/62 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг 2026 оны 04 дүгээр сарын 01-нээс 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Аяныг нутаг дэвсгэрийн хэмжээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Эрүүл мэндийн газар (Д.Нарантуяа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Сум, орон нутагтаа аяныг зохион байгуулах ажлын хэсэг томилж, нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулж, ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээ, мэдээллийг улс, орон нутгийн хэмжээнд сурталчлан ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Э.Эрболд)-д даалгасугай.

5.“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүнг 2026 оны 06 дугаар сарын 15, 2026 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хуралд танилцуулж ажиллахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010308

Сугар Ажил 2026 өдөр бүр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026. оны  
04 дүгээр сарын 02-ны/ний өдрийн  
А/232 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**“ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫ УДИРДАМЖ**

**Нэг. Аяны зорилго**

“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Хог хаягдлын тухай” хууль, аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, хог хаягдал, орчны бохирдол, доройтлыг бууруулах ажлыг зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэхэд оршино.

**Хоёр. Хамрах хүрээ**

Аймгийн хэмжээнд сум, баг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

**Гурав. Хэрэгжүүлэх хугацаа**

Аймгийн хэмжээнд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх дуустал хугацаанд зохион байгуулна.

**Дөрөв. Аяны үйл ажиллагааны чиглэл**

Аяныг хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах, иргэдийг соён гэгээрүүлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах, орчны бохирдлыг бууруулах, хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх гэсэн чиглэлээр зохион байгуулна.

**Нэгдүгээр чиглэл: Удирдлага зохион байгуулалтаар хангах**

- 1.1. “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх
- 1.2. “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах
- 1.3. Шатахуун түгээх станцуудтай гэрээ байгуулан ажиллах
- 1.4. Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэх, дүгнэх

**Хоёрдугаар чиглэл: Мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах**

- 2.1. Хог хаягдлын талаар иргэдийн мэдлэг, хандлага, оролцоог нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах

**Гуравдугаар чиглэл: Үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах**

- 3.1. Хог хаягдлыг үүсэхээс урьдчилан сэргийлэх, эх үүсвэр дээр нь ангилан ялгах

**Дөрөвдүгээр чиглэл: Хог хаягдлын талаар эрх зүй, эдийн засгийн зохицуулалтыг сайжруулах**


- 4.1. Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох журмыг батлах

**Тавдугаар чиглэл: Хог хаягдлын менежментийг сайжруулах**

- 5.1. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах
- 5.2. Аялал, жуулчлалаас үүдэлтэй хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх
- 5.3. Сумдыг шаардлагатай тоног төхөөрөмж, автомашинаар хангах

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны  
 01 дүгээр сарын 02-ны/ний өдрийн  
 А/232 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫГ 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
 АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Санхүүжих эх үүсвэр (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6	7	8	9
<b>1.Удирдлага зохион байгуулалтаар хангах</b>								
1.1	“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх	1.1.1.Аяны хүрээнд 2026 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргаар батлуулах	I улиралд	БОГ	БОНХОБТХ	-	Гүйцэтгэлийн хувь	100%
		1.1.2.Аяны захирамж, ажлын төлөвлөгөөг сумын Засаг дарга нар, байгууллагын дарга нарт хүргүүлэх	I улиралд	БОНХОБТХ	БОГ	-	Захирамж хүргэсэн сумын, тосгоны тоо	17
		1.1.3.Сумд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх	I улиралд	СЗДТГ	Багийн Засаг дарга, иргэд, ААНБ	Үйл ажиллагаа гаар	Төлөвлөгөө гаргасан сум, тосгоны тоо.	17
1.2	“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	1.2.1.Хаврын цэвэрлэгээний ажлыг 2 сарын хугацаатай, баяр наадмын үеийн цэвэрлэгээг 2 удаа, намрын цэвэрлэгээг 1 сарын хугацаатай зохион байгуулах.	IV/05-VI/05, VII/04-15 VIII/10-15 IX/25-30	БОГ	СЗДТГ	Үйл ажиллагаа гаар	Гүйцэтгэлийн хувь	100%
		1.2.2.Зудын эрсдэлтэй холбоотой болон бусад шалтгаанаар зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цэвэрлэх, халдваргүйжүүлэн устгах, ажлыг зохион байгуулах	II-III улиралд	Аймгийн МЭГ, СЗДТГ,	Малчид, иргэд	ОНТ	Гүйцэтгэлийн хувь	100%
1.3	Шатахуун түгээх станцуудтай гэрээ байгуулан ажиллах	1.3.1.Шатахуун түгээх станцуудын дэргэд хог хаягдал ангилан хийдэг хогийн сав байрлуулж, үйлчлүүлсэн зорчин явагсдын хог хаягдлыг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	СЗДТГ	ААНБ, ШТС	ААНБ-ын хөрөнгө	Ангилан ялгах хогийн сав суурилуулсан ШТС-н тоо	10

		1.3.2.Шатахуун түгээх станцуудын жорлонг стандартын шаардлага хангуулах	Жилдээ	ШТС	СЗДТГ	ААНБ-ын хөрөнгө	Стандартын шаардлага хангасан жорлонтой болсон ШТС-н тоо	3
1.4	Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэх, дүгнэх	1.4.1.Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг сумдаас хагас, бүтэн жилээр авч нэгтгэн БОНХОБТХ-т хүргүүлж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.	VI/15-20 X/15-25	БОГ	СЗДТГ	Үйл ажиллагаа гаар	Гүйцэтгэлийн хувь	100%
<b>2.Мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах талаар</b>								
2.1	Хог хаягдлын талаар иргэдийн мэдлэг, хандлага, оролцоог нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2.1.1.Олон нийтийн сүлжээгээр “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэл хүргэх	Аяны хугацаанд	ХМОНХА	БОГ, СЗДТГ	ОНТ	Олон нийтийн сүлжээнд байрлуулсан мэдээллийн тоо	20
		2.1.2.Хог хаягдлын тухай хууль, тогтоомжийг олон нийтэд сурталчлах зорилгоор энгийн ойлгомжтой контент (инфографик, гарын авлага, зөвлөмж) бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим сүлжээгээр дамжуулан тогтмол хүргэх.	II-IV улиралд	БОГ СЗДТГ, ТҮА,	Сайхан Монгол ТВ	ОНТ	Мэдээлэл хүргэсэн иргэний тоо	20,000
		2.1.3.Эх дэлхийн цаг үйл ажиллагааг жил бүр тогтмол зохион байгуулах	I улиралд	БОГ, ТҮА	БОГ	-	Үйл ажиллагаанд оролцсон иргэдийн тоо	50
		2.1.4.Тэг хаягдал (Zero Waste) болон 3R (Дахин ашиглах, Дахин боловсруулах, Хаягдлыг бууруулах) зарчмыг иргэд, аж ахуйн нэгжүүдэд таниулах сургалт зохион байгуулах	II-III улиралд	БОГ	СЗДТГ	-	Хамрагдсан иргэний тоогоор	100
<b>3. Үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах</b>								
3.1	Хог хаягдлыг үүсэхээс урьдчилан сэргийлэх, эх	3.1.1.Олон нийтийн арга хэмжээ, хурал цуглааныг нэг удаагийн хэрэглээнээс татгалзаж, байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулах	I-IV улиралд	Аймаг, сумын ЗДТГ, ААН, байгууллага	Сумын Засаг дарга, багийн Засаг дарга	Үйл ажиллагаа гаар	Байгальд ээлтэй байдлаар зохион байгуулсан	10

үүсвэр дээр нь ангилан ялгах						хурал, цуглааны тоо	
	3.1.2.Булган сум ангилсан хогийг ачих хуваарь гарган, ТҮА тусд нь тээвэрлэх ажлыг тогтмол зохион байгуулах	I-IV улиралд	СЗДТГ, ТҮА	Иргэд, ААНБ	Үйл ажиллагаа гаар	Гүйцэтгэлийн хувиар	100%
	3.1.3.Сумын төвийн томоохон зах, хүнсний дэлгүүрийн гадна талбайд нийгмийн хариуцлагын хүрээнд сумын хэмжээнд зай болон хуванцар цуглуулах цэгийг байгуулах	I-IV улиралд	СЗДТГ,	ААНБ	Үйл ажиллагаа гаар	Хогийн савтай болсон Дэлгүүрийн тоо	17
	3.1.4.Орон сууцны айл өрхүүдийг ангилан ялгах стандарт саваар хангах, шинээр ашиглалтад орох барилгуудыг хог ангилах бункертэй хүлээн авч иргэдийг хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан хаядаг дадал хэвшилтэй болгох	II-III улиралд	БОГ	АЗДТГ, СЗДТГ	ОНТ	Хог хаягдлаа ангилан ялгаж хэвшсэн байрны тоо	5
	3.1.5.Хог ангилан ялгаж хэвшсэн жишиг гудамж, орон сууцыг бий болгох нөлөөллийн ажил зохион байгуулах	I-II улиралд	СЗДТГ	Айл, өрх, БОГ	Сумын төсөв, ААНБ-ын хөрөнгө	Ангилж хэвшсэн гудамж, орон сууцны тоогоор	1
	3.1.6.Гэр хорооллын айл өрхийг хог ангилан ялгах зориулалттай хогийн савтай болгох ажлыг үргэлжлүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг зохион байгуулах	Жилдээ	СЗДТГ	ААНБ, иргэд	ОНТ	Ангилан ялгах савтай болж, хогоо ангилан ялгаж хэвшсэн өрхийн тоо	50
	3.1.7.Дахивар нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлж, үйл ажиллагаа явуулах газрын асуудлыг орон нутгийн төлөвлөгөөтэй уялдуулан шийдвэрлэх, урамшууллаар дэмжих замаар дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх хуванцар болон бусад хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх.	Жилдээ	ТҮА, СЗДТГ, БОГ	ААНБ, иргэд	Үйл ажиллагаа гаар	Ангилж, тушаасан хог хаягдлын хэмжээ	20тн.
		I-IV улиралд		Малчин өрх			10

		3.1.8.Хүнсний хог хаягдлыг бордоо болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүнсний хог хаягдлын хэмжээг бууруулах		СЗДТГ, Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч		Үйл ажиллагаа гаар	Төсөлд хамрагдсан иргэн, ААНБ тоо	
<b>4. Хог хаягдлын талаар эрх зүй, эдийн засгийн зохицуулалтыг сайжруулах</b>								
4.1	Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох журмыг батлах	4.1.1.Сумд энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох, бүтцийн судалгаа хийх /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 25-ны өдрийн А/368 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалаар/	I-IV улиралд	СЗДТГ,	БОГ	-	Норматив тогтоосон сумдын тоогоор	100%
		4.1.2.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хуульд нийцүүлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар шинэчлэн тогтоох	I-IV улиралд	СЗДТГ	БОГ	-	Батлагдсан тогтоолын тоо	
		4.1.3.Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлах	I-IV улиралд	СЗДТГ	БОГ	-	Батлагдсан тогтоолын тоо	
		4.1.4.Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг батлуулах	II-IV улиралд	БОГ	АЗДТГ	-	Батлагдсан журмын тоо	1
		4.1.5.Сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлаж, хэрэгжүүлэх	I-III улиралд	СЗДТГ	БОГ	-	Менежментийн төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн сумын тоо	16
<b>5. Хог хаягдлын менежментийг сайжруулах</b>								
5.1	5.1 Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах	5.1.1.Сумын хэмжээнд электрон хог хаягдал, зай, аюултай хог хаягдлыг цуглуулж аймгийн аюултай хог хаягдал түр хадгалах агуулахад	II-IV улиралд	СЗДТГ	БОГ, ТҮА	-	Цуглуулсан электрон хог хаягдлын хэмжээ (кг)	200 кг

		шилжүүлэх/дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх						
		5.1.2.Аюултай хог хаягдлын талаар сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, иргэдийн ахуйн аюултай хог хаягдлын талаарх хандлага, дадлыг өөрчлөх	I-IV улиралд	БОГ, СЗДТГ	ТҮА	-	Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо	100
		5.1.3.Электрон хог хаягдал цуглуулах өдөрлөг зохиож байгуулах	III-IV улиралд	БОГ, ТҮА, СЗДТГ	АЗДТГ	-	Гүйцэтгэлийн хувь	100%
		5.1.4.Аюултай хог хаягдлын жилийн тайлан мэдээг гаргаж, мэдээллийн сан үүсгэх	IV улиралд	БОГ, СЗДТГ,	ААНБ		Мэдээллийн сан	1
5.2.	Аялал, жуулчлалаас үүдэлтэй хог асуудлыг шийдвэрлэх	5.2.1.Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч нүхэн жорлонгийн тоог үе шаттай бууруулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	АЗДТГ, БОГ, СЗДТГ	ААНБ, иргэд	-	Стандартад нийцсэн жорлонгийн тоо өссөн дүнгээр	2200
		5.2.2.Аялал жуулчлалаас үүсэх хог хаягдал, орчны бохирдлын асуудлыг отоглох цэг байгуулж, хувийн хэвшил, иргэнд менежментийн гэрээний дагуу хариуцуулах	Жилдээ	ААНБ	СЗДТГ	Үйл ажиллагаа гаар	Менежментийн гэрээний дагуу хариуцагчтай отоглох цэгийн тоо	1
		5.2.3.Аялал жуулчлал, амралтын газрууд "Ирлээ, явлаа-Цэвэр" аян өрнүүлж, аялагч амрагчдад зориулсан сурталчилгааг хийх	Жилдээ	ААНБ, БОГ	СЗДТГ	Үйл ажиллагаа гаар	Сурталчилгааны тоо	3
		5.2.4.Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн үеэр хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Зохион байгуулсан сумын ЗДТГ	БОГ	ОНТ	Гүйцэтгэлийн хувь	100%
		5.2.5.Аялал жуулчлалын эвент арга хэмжээнд ариун цэврийн асуудлыг шийдвэрлэж, хөрс бохирдуулдаггүй жорлонг ашиглах	Тухай бүр	СЗДТГ	БОГ, Булган сумын ТҮА, ААНБ	ОНТ	Гүйцэтгэлийн хувь	
		5.2.6.Аялал жуулчлал, амралтын газруудын Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх	II-IV улиралд	БОГ	СЗДТГ	ОНТ	Хяналт шалгалтад хамрагдсан ААНБ тоо	10
		5.2.7.Аялагч жуулчдын төвлөрөл үүсдэг байгалийн үзэсгэлэнт газар, нуурийн эргийн болгох ариун	II-III улирал	АЗДТГ, БОГ	СЗДТГ	120.0	Жорлонгийн тоо	10

		цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэх (Харгал нуур)						
		5.2.8.Сум бүр айл өрх, албан байгууллагын нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах	II улирал	СЗДТГ, ЭМТ	Багийн Засаг дарга, айл өрх	Үйл ажиллагаагаар	Хамрагдсан айл өрхийн тоо	100
5.3.	5.3. Сумдыг шаардлагатай тоног төхөөрөмж, автомашинаар хангах	5.3.1.Бохир соруулах тоноглогдсон автомашинаар хангах	I- II улирал	АЗДТГ, БОГ	ААНБ	240.0	Нийлүүлсэн машины тоо	4
		5.3.2.Бохирдсон хөрсийг ариутгах Дук автомашинаар хангах	I- II улирал	АЗДТГ,БОГ	СЗДТГ	70	Нийлүүлсэн машины тоо	1

--o00o--